



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№64 /278/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.04.01

## Цаг үе, үйл явдал

### ЭРДЭМТЭД ТАВАН ТОЛГОЙД ЧУУЛЖ БАЙНА

Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт зориулсан хоёрдугаар хуралдааныг өнөөдөр Таван толгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд зохион байгууллаа.

Энэ удаагийн эрдэм шинжилгээний онол, арга зүйн хурлын зорилго нь Шинжлэх ухааны салбарын бодлогын шинэчлэл, тулгамдаж буй асуудлаар удирдлагын болон эрдэм шинжилгээний байгууллагууд санал солилцох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг цэргийн шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох, нэгдсэн ойлголтод хүрэхэд чиглэгдсэн юм. Эрдэм шинжилгээний хурлын ажиллагаанд Батлан хамгаалахын дэд сайд, БХЯ-ны ШУТЗ-ийн дарга Б.Баярмагнай, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Мөнхбат, Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал, Батлан хамгаалах яамны Стратегийн

бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, Боловсрол шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баттогтох, Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Д.Одгэрэл, яамдын ШУТЗ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга нар болон ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан, БХЭШХ-ийн захирал хурандаа Б.Эрдэнэбат болон эрдэмтэн судлаачид оролцлоо. Хурлыг ажиллагааг нээж Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа үг хэлсэн бөгөөд тэрээр БХЯ-ны ШУТЗ-өөс "Алсын хараа-2050" баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд батлан хамгаалах талаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байгааг онцлон

дурдаж, эрдэмтэн судлаачдын хурлын ажиллагаанд амжилт хүслээ. Боловсрол шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баттогтох хурлын ажиллагаанд үг хэлэхдээ Шинжлэх ухааны тэргүүлэх зорилго, зорилтуудыг ханган биелүүлэхэд Та бидний хамтын хүчин чармайлт, идэвх санаачилга цаашдын ажиллагаа нэн чухал гэдгийг онцолсон юм. Энэхүү хуралд Боловсрол шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баттогтох "Шинжлэх ухааны салбарын бодлого, шинэчлэл", БШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Оюунцэцэг "Улсын захиалгатай төсөл, цөм технологийн төслийг оновчтой захиалах, хэрэгжилтийг хангах асуудал", Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Мөнхбат "ШУТЗ болон

яамдын ШУТ-ийн зөвлөлийн үйл ажиллагааны уялдааг хангах асуудал", БХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Содномцог "Батлан хамгаалах яамны ШУТ-ийн зөвлөлийн үйл ажиллагаа" сэдвээр тус тус илтгэл мэдээлэл хийсэн. Хуралд оролцогчид хурлаар хэлэлцсэн илтгэлүүдтэй холбоотой шинжлэх ухаанч, асуудлын мөн чанарт хандсан, цаашид санаа авахуйц олон чухал асуулыг асууж хэлэлцүүлэг өрнүүлсэн нь хурлын үйл ажиллагааг улам сонирхолтой болгосон бөгөөд хуралд оролцогчид сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байлаа. Үдээс хойш зочид төлөөлөгчид Батлан хамгаалах яамны инноваци шингэсэн техник, тоног төхөөрөмжийн үзэсгэлэн болон буудлагын талбайд тусгай зориулалтын "Чоно", "Хилэнцэт", "Мазаалай", "Ёл" автомашинуудын буудлага, жолоодлогыг үзэж сонирхоно.



### ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН НЭГЖ, АЖЛЫН ХЭСГИЙНХЭН СУРГАЛТАД ХАМРАГДАВ



Батлан хамгаалах салбарын төсөв, төрийн өмчийн хөрөнгийн захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, түүнд тавигдах дотоод хангалтын сайжруулах зорилго бүхий сургалт өчигдөр зохион байгуулагдав. Тус сургалтад

Төрийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дотоод хяналт шалгалт шалгалтын нэгж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн танхимаар хамрагдсан бол цахимаар Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, БХЯ-ны харьяа

байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгж ажлын хэсгийн бүрэлдэхүүн оролцов. Сургалтын хүрээнд Батлан хамгаалах салбарын 2021 оны дотоод аудит, хяналт шалгалтын дүнг танилцуулж, анги байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт тавих, барилга техникийн хяналтын чиглэлээр холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд дотоод хяналт тавих зэрэг олон сургалтуудын албаны хүмүүс орлоо.

Түүнчлэн Монгол Улсын гавьяат багш, доктор профессор, бэлтгэл дэд хурандаа Б.Галиндэв урилгаар оролцож Төрийн алба хаагчийн ёс зүйн талаар хичээл орсон юм.

Мөн Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар оролцож нийт сургалтад оролцогчдод хандан "Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн, мэргэшсэн, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх зорилтын хүрээнд, төрийн өмч хөрөнгийг үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжих, салбарын хэмжээнд санхүү, төсвийн хариуцлагатай удирдлагыг хэрэгжүүлэхэд

Батлан хамгаалахын сайд онцгойлон анхаарч байна. Энэ ч үүднээс сүүлийн 2 жилийн хугацаанд Батлан хамгаалахын хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналт шалгалтын нэгжүүд, нэгтгэл, анги байгууллагын ажлын хэсгийн чиг үүрэг, ажлын уялдаа холбоог зохицуулах дүрэм журмууд батлагдан, хяналт шалгалтын бүтцийн нэгжүүд нэгдмэл бодлого, төлөвлөгөөтэй ажиллаж байгаа юм. Мөн батлан хамгаалах салбарын нэгдмэл хяналтын гол зорилго нь Батлан хамгаалахын сайдын хуулиар хүлээсэн үүргүүдийг нэгдсэн бодлогоор хангаж Зэвсэгт хүчинд иргэний хяналт тавих ажилд дэмжлэг үзүүлж байна. Тиймээс өнөөдрийн сургалтаар байгууллагад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахын ач холбогдлыг ойлгуулах, албан тушаалтнуудын төрийн өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалттай холбоотой үүрэг, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, дотоод аудит санхүүгийн хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчил дутагдлыг цаашид засаж арилгахад үр дүнгээ өгнө гэдэгт итгэж байна" гэсэн юм.

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
7	-8

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
42	29

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,000.00	3,030.0
EUR	3,520.0	3,570.0
CNY	492.00	496.00
RUB	36.00	37.00
JPY	26.50	27.50
KRW	2.62	2.68

## ЗУРХАЙ

2022.04.01 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 30/

ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ХОЁР ХАР ХӨХ БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Эрлэг лугаа учирна

Наран ургах, шингэх:

06.31-19.21

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Өтлөх үхэхүй

Суудал: Гал

Энэ өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг мүүд нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, лусыг тахиж, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, сэтгэлд сэвтэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,272,439 /69.9%/	2,174,613 /66.8%/	1,032,876 31,7%
		115,185 /3,5%/

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8435 +112	3	8311

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 488,566,474
Эдгэрсэн	Нийт: 423,374,275
Нас барсан	Нийт: 6,166,976

СУРЬЕГИЙН НАС БАРАЛТ 2020 ОНД СУЛИЙН 10 ЖИЛД АНХ УДАА ӨССӨН ДЭЛХИЙ ДАХИНЫ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ НАС БАРАЛТЫН 2 ДАХЬ ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН БОЛЖ БАЙНА

ЭРЧИЛ МЭНДИЙН ТОГТЛООГ СЭЖЖҮҮЛЭХ ЦАР ТАХИЙН БЭЛГЭН БАЙДЛЫГ ХАНГАХ СЭРГИЙН БОЛМОНТОЙ НАС БАРАЛТЫГ ЗӨГСОХЫН ТҮЛД СУРЬЕГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЙГ ЗӨНӨ

ХӨРӨНГӨ ОРУУЛЬЯ

Цахим шууданд

# “ТЭМҮҮЖИН ӨРЛӨГ”-ИЙНХӨН ШИНЭ СПОРТ ЗААЛ БОЛОН ГАЗАРЗҮЙН КАБИНЕТТАЙ БОЛЛОО



байна. Спорт заал болон газарзүйн кабинетийн албан ёсны нээлтийн арга хэмжээг энэ 3-р сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Тус нээлтийн үйл ажиллагаанд БХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, хурандаа С.Ванчинхүү, БЗД-ийн ЗДТГ-ын Цахим хөгжил, төрийн үйлчилгээ хариуцсан Засаг даргын орлогч Г.Золзаая, УБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан, БЗД-ийн Боловсролын хэлтсийн дарга Б.Ганбат, Тэмүүжин Өрлөг сургуулийн захирал хурандаа Д.Бат-Эрдэнэ нар оролцлоо.

Нийслэлийн Тэргүүний Ерөнхий Боловсролын “Тэмүүжин Өрлөг” сургууль сургалтын орчин нөхцлийг сайжруулах ажлын хүрээнд анх удаа ороннугийн санхүүжилтээр

40 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар спорт заалны засварын ажил болон газарзүйн хичээлийн орчин үеийн тохижилт бүхий жишиг кабинетийг ашиглалтад оруулаад



## ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД БАРИЛГЫН 3 МЭРГЭЖЛЭЭР СУРГАЛТАД ХАМРАГДАВ

### Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу 2021 онд хугацаат цэргийн албанд татагдан ирсэн дайчдыг барилгын мужаан, цахилгаан, сантехник зэрэг гурван мэргэжлээр 2022 оны 3 дугаар сарын 3-31 хооронд 1 сарын хугацаатай зохион байгуулагдав.

Сургалт 40 цагийн онол, 160 цагийн дадлага нийт 200 цагийн сургалтыг Орхон аймгийн МСҮТ-ийн материаллаг баазыг түшиглэн явууллаа. Тус сургалтад хоёр ахлагч, цэргийн гэрээт алба хаагч, 38 хугацаат цэргийн алба хаагч нийт 42 цэргийн алба хаагч хамрагдлаа.

Сургалтын төгсгөлд онолын болон дадлагын шалгалтад цэргийн алба хаагчид амжилттай дүн үзүүлэн чадамжийн гэрчилгээ гардан авлаа.

Ахмад Т.МӨНХ-ЭРДЭНЭ



## ЭХ ОРОНЧ ӨДӨР



Увс аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх, хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Сурагчдын нэг өдөр” арга хэмжээг Хилийн

цэргийн 0245 дугаар анги, Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Энэ үеэр сурагчдыг ангийн үйл ажиллагаатай танилцуулж, Монгол Улсын хил бүрэлдэн

тогтсон түүх, хилчин баатруудын байгуулсан эрэлхэг гавьяа, гэрээт цэргийн алба хаах журам, хугацаат цэргийн алба хаахын ач холбогдлын талаар яриа таниулга хийж, хилчдийн хувцас, тусгай хэрэгслүүдийг танилцууллаа.

## ТЭНГЭРИЙН ХАРУУЛ” БАГ ГУТГААР БАЙР ЭЗЭЛЛЭЭ



### Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Зэвсэгт хүчний анги байгууллагуудын дунд зохион байгуулагдсан “Замын хөдөлгөөний хууль, дүрмийг хэн сайн мэдэх вэ?” тэмцээнд Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн “Тэнгэрийн харуул” баг гутгаар байр эзэллээ. ЗХЖШ-ын МТГ-ын Техникийн хэлтэс, Тээврийн хяналтын албатай хамтран зохион байгуулсан “Замын хөдөлгөөний хууль, дүрмийг хэн сайн мэдэх

вэ?” тэмцээнд Улаанбаатар цэргийн хүрээний 14-н нэгтгэл, анги, байгууллагууд ур чадвар авхаалж самбаа гарган амжилттай өрсөлдлөө. Тус тэмцээн нь багийн мэндчилгээ, зөрчлийн хуулиар бэлтгэсэн асуултад хариулах, замын хөдөлгөөний дүрмийн тест бөглөх, гэрийн даалгавар /Замын хөдөлгөөний дүрмийн анхааруулга бичлэг/ гэсэн үндсэн 4-н төрлөөр өрсөлдөж хурандаа Ш.Цэрэнбат захирагчтай Цэргийн

гавьяаны одонт Зэвсэгт хүчний 065 дугаар анги гутгаар байранд шалгарлаа. Тэмцээнд захирагчийн зэвсэглэл техник, хариуцсан орлогч дэд хурандаа Н.Эрдэнэ-Очирын удирдлагаар албаны дарга авто техникийн офицер хошууч Ц.Ариунболд, соёл хүмүүжлийн офицер ахмад З.Анхбаяр, ахлах ахлагч Б.Доржготов, ахлагч Б.Одхүү, дэд ахлагч М.Учралт З.Даваадэмбэрэл нар оролцлоо.

